

ДЭЛХИЙН

7

ТИВИЙН НОЁН ОРГИЛД
ГАРСАН АНХНЫ МОНГОЛ ХҮН



*ОХУ-ын нутагт орших
Их Алтай нурууны ноён оргил Белуха
(4506 м) уулын авиралт хийхийн
өмнө бааз лагер хүрэх замд
2016 оны 08 сар*



Ярилцсан
хөтлөгч, редактор
Лхагважавын
СЭЛЭНГЭ

“СҮЛД” телевизийн “Сувд”
нэвтрүүлэгээр Монгол Улсын Гавьяат
тамирчин, Уулын спортын олон улсын
хэмжээний мастер Б.ГАНГААМАА-тай
хийсэн ярилцлагыг Та бүхэндээ хүргэж
байна.

“ЦАСТ УУЛЫН ЦАГААН ИРВЭС”

БАДАМГАРАВЫН ГАНГААМАА



Б.Гангаамаа бол дэлхийн долоон тивийн ноён оргилд хөл тавьсан (Seven summits хийсэн) анхны монгол хүн бөгөөд Монгол Улсын Гавьяат тамирчин, Уулын спортын олон улсын хэмжээний мастер юм.

- 2016 он бол эдийн засгийн хямрал гээд олон олон хүндрэл бэрхшээлтэй жил болж өнгөрлөө. Энэ оны төгсгөлд

сонссон, монголчууд бидний омог бахархлыг өөрийн эрхгүй төрүүлсэн хамгийн сайхан мэдээ бол монголын уулчин, тэр тусмаа монгол эмэгтэй анх удаагаа Дэлхийн долоон тивийн ноён оргилд хөл тавьсан мэдээ байлаа. Энэ сэтгэл догдуулсан сайхан мэдээг дуулгасан хүн бол монголын спортын түүхэнд домог болон бичигдэж байгаа Б.Гангаамаа юм. Бидний

урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Танд баярлалаа. Ингээд хоёулаа яриагаа Таны хамгийн сүүлд хийсэн SEVEN SUMMITS (Долоон тивийн ноён оргил)-ээс эхлэе. SEVEN SUMMITS хийх, дэлхийн долоон тивийн ноён оргилд гарах санаа Танд хэдийнээс төрөв, бэлтгэлээ яаж хийв, хэр удаан бэлтгэл хийв?

- Долоон тивийн ноён оргил гэдэг бол уулчин бүрийн мөрөөдөл байдаг. Би олон жилийн өмнөөс үүний төлөө хөдөлмөрлөж ирсэн. Уулчин болоод, уулын спорт гэдэг их айлын босгоор алхаж ороод 27 жил болсон байна. Сүүлийн бараг хориод жил нь үүнийг мөрөөдөж ирсэн. Яг энэ долоодох ноён оргилд гарна гэж гурван жилийн өмнөөс бэлтгэлээ базааж эхэлсэн. Винсон Массиф оргил, Антрактид тив бол миний бодол санаанаас их хол байсан. Яагаад гэвэл зөвхөн надаас ч биш, ер нь дэлхийгээс, хүн төрлөхтөнөөс, эх газраас их хол оршдог хамгийн их үнэтэй цагаан тив байсан. Зургаан тивийн ноён оргил дээр гарчихаад л шулуудсан даа. Ингээд бэлтгэл сургуулилтаа хийж, хөрөнгө мөнгөө цуглуулж, 2016 ондоо багтаж SEVEN SUMMITS-ээ хийнэ гэж төлөвлөж ажилласан.

- Уулын спорт бол үзэгчгүй спорт, үзэгчгүй байна гэдэг бол санхүүжилтгүй байна гэсэн үг. Тэгэхээр мөнгө босгоно, санхүүжилт олно гэдэг Таны уулын спортоор хичээллэсэн энэ он жилүүдэд SEVEN SUMMITS хийхээс илүү хамгийн хүнд даваа байсан байх. Та яаж мөнгө хөрөнгө босгов. Ямар ямар байгууллагууд Таныг спонсорлож, Таны энэ амжилтыг авчирахад тус дэм болсон бэ?



MOUNT EVEREST

(Ази)

Далайн түвшинөөс дээш 8848 м

Б.Гангаамаа 2011.05.21-нд энэ оргилд гарсан.



MOUNT EVEREST

- Ер нь уулын спорт өртөг өндөртэй. Замын з ардал, хэрэглэж байгаа хувцас, багаж хэрэгсэл гээд их өндөр өртөгтэй шүү дээ. Анхнаасаа л уулын спортод хөл тавьсан болохоор эхнээсээ эцсээ хүртэл л явсан. Анх намайг ууланд орж байхад мэдээлэл хомс байсан. 2004, 2005 он бол манай уулын спортын тэсрэлтийн үе гэж хэлж болно. Эверестэд монгол хүн хөл тавиад ирэнгүүт л мэдээлэл их цацагдаж эхэлсэн. Тэр цаг мөчөөс хойш бас ч хүмүүс

ойлгодог болсон. Хүмүүс ч тэр, байгууллагууд ч тэр, төр засаг ч тэр тодорхой зорилго тавиад, тодорхой амжилт гаргаад байгаа хүмүүсийг дэмждэг болсон. Өнөөдрийн миний амжилтын ард маш том баг, далд фронт байгаа. Энэ бол надад тусалж дэмжиж, спонсорлож, зохион байгуулж явсан тэр олон хүмүүс юм. Энэ баг бүрэлдэхүүн, спортын салбарын олон дарга нар, мэргэжилтнүүд, олон компаний захирлууд, төр засгийн ажилтнууд, тэд бүгд

миний ард зогсож миний амжилтыг өлгийдөж авсан хүмүүс шүү дээ. Болдогсон бол энэ бүх хүмүүсийн нэрийг дурьдмаар л байна. Энэ бүх хүмүүсдээ баярлалаа л гэж хэлье дээ. Өөрөөр миний баярласнаа илэрхийлэх үгийн баялаг дутаж байна. Та нартаа маш их баярлалаа.

- Энэ бүх хүмүүсийн ачийг Та амжилтаараа хариуллаа шүү дээ. Монголынхоо түүхэнд алтан үсгээр бичигдэх амжилт



Б.Гангаамаа энэ оргилд 48 удаагийн оролдлогоор 39 удаа оргилд амжилттай гарсан.

өрнүүлээд маш том хандивлагч болсон. Зам, тээврийн сайд Д.Ганбатад үнэхээр их баярлаж байна. Мөн Эрчим хүчний сайд П.Ганхүүд баярлалаа гэж хэлмээр байна. Бас системийнхээ хэмжээнд хандив өргөсөн. УИХ-ын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд бас баярлаж байна. Хамтарч ажиллая гэсэн санал тавиад ороход хүлээж авсан. Би судалгаа шинжилгээний ажил хийж ирсэн. Тэгээд миний зардалд хандив өгч маш сайхан хамтарч ажилласан байгаа.

гаргалаа. Хамт олон, багш нар, спонсоруудынхаа ачийг үүнээс илүү яаж хариулах вэ л гэж би хувьдаа бодож байна.

- Та тэгж бодож байгаа бол үнэхээр их баярлалаа. Би баярлалаа гэж хэлэхээс өөр юм үнэхээр хийж чадахгүй юм даа. Миний ард 20 жилийн турш үнэнч зогссон Та нартаа үнэхээр их баярлалаа гэж хэлье дээ. Сүүлийн миний явах гэж байгаа энэ зорилгыг хүмүүс маш сайн ойлгосон байна лээ. Тийм ч учраас намайг өөрөө эхэлж хандаагүй байхад Австралийн сайхан сэтгэлтэй иргэн Жос намайг хайж олоод надад туслая гээд хандив өгч тусалж байсан. Мөн монголчууддаа бас хандивын аян зарласан. Монголчууд маань 5000 төгрөгнөөс эхлээд 50 мянган төгрөг, 100 мянган төгрөг, нэг сая төгрөг хүртэл өгч тусалсан. Олон хүн дансаар мөнгө шилжүүлсэн. Энэ бүхэн нийлээд их нэмэр болсон. Түүнээс гадна байгууллагууд системийнхээ дотор хандив өрнүүдсэн. Томоохноос нь нэрлэхэд Монголын Авто замчдын холбоо замынхаа компаниудын дунд хандивын аян

**Бид хамтын хүчээр
Дэлхийг хурааж чадлаа.
Та нартаа баярлалаа**

*Монгол Улсын Гавьяат Тамирчин,
Олон Улсын Хэмжээний Мастер
Бадамгаравын ГАНГААМАА*



Яг энэ бүхнийг зангидаж ерөнхий зохион байгуулагчаар ажилласан УИХ-ын гишүүн, нутгийн ах Д.Хаянхярваа танд маш их баярлалаа. Мөн намайг байнга дэмжиж байдаг Монголын уулчдын үндэсний холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Сутайн бор” клубийн эзэн А.Батсүх ахдаа үнэхээр их баярлаж байна. Эрүүл мэнд, спортын сайд асан С.Ламбаа, Ю.Байгал ерөнхийлөгчтэй Улаанбаатар хот дахь Завханчуудын спорт холбооныхон, Эрдэнэт хотын үе үеийн Засаг дарга нар, эрдэнэтчүүддээ, мөн надтай 10 гаруй жил хамтарч ажиллаж байгаа, миний ард байнга зогсож байдаг “Mongolia Expeditions” компаний хамт олон залуучууддаа бас баярлалаа гэж хэлмээр байна. Мөн надтай

зургаан жил хамтарч ажиллаж миний эрсдэлийг дааж байгаа “МИГ” даатгал компанийхандаа баярлалаа. Turkish airlines байна. Туркийн компани ч гэсэн миний сүүлийн гурван удаагийн авиралтын ивээн тэтгэгчээр ажилласан. Мөн “THE SEVEN SUMMITS” Герман улсын уулын хэрэгслэлийн дэлгүүр миний долоон оргилын авиралтын багаж хэрэгсэлийн ивээн тэтгэгчээр ажилласан байгаа. Энэ дашрамд мөн миний K2 ууланд авиралтыг бүхэлд нь ивээн тэтгэсэн Соёл, спорт, аялал жуулчлалын яам (хуучнаар), түүний сайд асан Ц.Оюунгэрэлд үнэхээр их баярлаж явдгаа хэлье. Энэ мэтчилэн маш олон ивээн тэтгэгчид байна. Тэгэхээр энэ олон ивээн тэтгэгчийн ачийг хариулж чадах юм нь миний амжилт л юм даа.

- Тэгэхээр Та бид хоёрын ярьж байгаа уулын спорт тэр дундаа өндөр уулын авиралтын төрөл бол хөл бөмбөг шиг хэдэн мянган үзэгчдийг суулгаад тэдний уухай түрлэг, асар их сэтгэл хөдлөлийн дундуур спонсорлогч компаниуд реклам сурталчилгаагаа байнга явуулж байдаг маш их мөнгө эргэлддэг ийм спорт биш нь ойлгомжтой. Гэхдээ л сүүлийн үед бид өндөр уулын авиралтын тухай баримтат кинонууд үзэж байна. Мөн энэ чиглэлийн мэдээ мэдээлэл гарч манай монголд энэ спортыг дэмжиж спонсорлодог байгууллагууд байдаг болсон юм байна гэж Таны ярианаас ойлголоо. Таны саяын хамгийн сүүлд очоод ирдэг Антрактид тив бол манай дэлхий ертөнцийн доод хязгаар юм. Антрактид гэж бодохоор нүд чихгүй цасан шуурга тавсан, амьд амьтан байх аргагүй -90°С хүртэл хүйтэрдэг нүд алдам цагаан тал гэж төсөөлөгддөг л дөө. Бас айдас хүрмээр ч юм шиг, хар дарсан зүүд ч юм шиг. Тэгэхээр энэ хол аян замыг Та яаж туулав?

- За ер нь тиймээ. Манай дэлхийн өлмий гэж ярьдаг. Энэ газар нутаг бол яг үнэндээ цэлийсэн цагаан тал шиг л харагдаж байсан. Ерөөсөө цагаан, цэнхэр гэсэн хоёрхон



ACONCAGUA

(Өмнөд Америк)

Далайн түвшинөөс дээш 6962 м

Б.Гангамаа 2016.01.13-нд энэ оргилд гарсан.

өнгө л байдаг юм билээ. Цэнхэр тэнгэр, цав цагаан тал. Энд хүрэхэд маш хол замыг туулсан. Нэг талдаа 6 дамжиж ниссэн. Turkish airlines миний нислэгийн эх газрын хамгийн сүүлийн цэг хүртлэх нислэгийг санхүүжүүлсэн. Turkish airlines-аар Истанбул, Бразил, Чилийн Сантьяго, Пунта-Аренас гэдэг Латин Америкийн яг үзүүрийн хот дээр ирж олон улсын нислэг буюу орон нутгийн нислэгүүд өндөрлөж байгаа юм. Тэндээсээ цаашаа тусгай нислэгээр ИЛ-76 гэдэг цэргийн зориулалттай, орос нисгэгчидтэй онгоцоор (гэхдээ Казакстаны далбайтай онгоц байсан) Антрактид тив буюу Холбооны мөсөн гол (Union Glacier) дээр буусан. Эх газрын үзүүрийн цэгээс Холбооны мөсөн гол хүртэл 3000 гаруй км. Энд ирэхэд 4 цаг 30 минут нисдэг юм байна лээ. Бид нар Аргентины хамгийн үзүүрийн Ушуай (Ushuaia) гэдэг хотоос хүмүүс авсан учраас 6 цаг ниссэн.



- Хэрвээ эх газрын хамгийн үзүүрийн цэгээс Холбооны мөсөн гол хүртэлх агаарын замыг туулах явцад цаг агаар муудвал яах вэ? Эргэж буцаж явах уу? Антрактидад цаг агаар муудана гэдэг бол бидний мэддэг секундэд 18 м-ийн хурдтай шуурна гэсэн үг биш, нүд чихгүй цасан шуурга тавьдаг гэсэн. Энэ үед онгоц

нисэх ямар ч боломжгүй юм байна лээ.

- Антрактид нисдэг онгоц бол иргэний агаарын тээврийн онгоцтой адилгүй. Чадал хүч ихтэй, гаднаас нь харсан ч аймаар том махчин шувуу ч юм шиг. Иргэний агаарын тээврийн онгоц 11 мянган метрийн өндөрт





нисдэг бол энэ онгоц 12 мянган метрт нисдэг. Нэгэнт эх газрын үзүүрийн цэгээс нисээд замын талдаа орсон тохиолдолд эргэж буцна гэсэн ойлголт байдаггүй байх, бид нар буцаагүй болохоор мэдэхгүй байна. Цаг агаар сайхан, баталгаатай нөхцөлд л нисдэг юм байна билээ. Холбооны мөсөн гол гэдэг тэр том кемп (Camp)-д бүх юм байдаг. Энэ кемп улирлын чанартай. 10 дугаар сарын сүүлчээс эхлээд 2 дугаар сарын 01 хүртэл үйл ажиллагаа явуулдаг. Маш том олон улсын лагерь. Холбоо харилцаа /гэхдээ сансарын утас/ барих, цаг агаарын мэдээ авах гээд боломжуудыг бүрдүүлсэн байдаг. Яг тэр орчныг Антрактидын нийслэл нь гэж хэлж болно. Хамгийн цэвэр уул, хамгийн цэвэр тив тэнд л байдаг юм байна лээ. Тэнд хүмүүс гурван чиглэлээр очдог. **Нэгд** ууланд авирах экспедиц, Винсон Массиф ууланд авирахаар очдог. **Нөгөөдөх** нь өмнөд туйлын 90 градус дээр очдог. Энд 111 км, 222 км-ыг цанаар явж очдог. **Гуравдахь** нь судалгаа шинжилгээний баг буюу туйл судлал, мөсөн гол судлалынхан очдог. Эхний хоёр нь спортын буюу адал явдал хайж яваа хүмүүс, гуравдахь нь судалгааныхан.

- Та Винсон Массиф ууландаа хэзээ гарав, хэдэн градус орчим хүйтэн байв?
- Антриктид тивд намайг байх хугацаанд цаг агаар тийм ч муудаагүй. Маш сайхан байсан. Зуны улирал байсан, гэхдээ зуны улирал ч гэсэн муудахдаа



DENALI

(Хойд Америк)

Далайн түвшинөөс дээш 6194 м

Б.Гангаамаа 2015.05.27-нд энэ оргилд гарсан.

хүрвэл аймшигтай мууддаг гэж ярьдаг. Гэхдээ аз болоход цаг агаар муудаагүй. Мөсөн гол дээрээ дулаахан байсан. Би бас давхар цаг уурын судалгааны хэмжилт хийж ирсэн. Харин оргил дээрээ бол миний багажны заалтаар -32°C - 52°C гэж гарсан байсан.

- Та оргилд өдөр гарсан уу, шөнө гарсан уу?

- Цагийнхаа хэмжилтээр бол одоо шөнийн 2 цаг, шөнийн 3 цаг болж байна даа гэхээс зуны улиралдаа харанхуй болдоггүй газар, мөнхийн 24 цаг өдөр байдаг. Ер нь олон сонин юм байдаг. Тэрнээс онцгойлж гурвыг нь хэлэхэд, нэг нь нар баруунаасаа гараад зүүн тал руугаа жаахан тонгойгоод уулын цаагуур ороод жаргадаггүй. Бидний ярьдаг нар зүүнээс манддаг гэдэг нь худлаа юм байна лээ шүү (инээлдэв). Хоёрдахь сонин нь гэхээр маш хуурай. Чийг гэдэг бол гурван юмнаас бий болдог. Нэг нь ногоон ургамлаас, хоёрдахь нь бороо орж байж чийг авна. Гуравдахь нь цас хайлж ууршиж байж чийг авна. Эдгээрийн аль нь ч байхгүй болохоор маш хуурай. Тиймээс шингэн юм маш их уух хэрэгтэй болдог.

За тэгээд гуравдахь сонин юм нь ердөө цэнхэр цагаан гэсэн хоёрхон л өнгө байдаг.

- Антрактид тив бол дэлхий нийтийн дундын өмч. Өнөөдөр Антриктид тив дээр сөөм ч газрыг ямар ч улс орон өмчилж аваагүй байдаг юм билээ. Энэ ч утгаараа дэлхийн олон орны судалгаа шинжилгээний баг очиж судалгаа шинжилгээ хийдэг. Дээр нь дэлхийн домогт уулчид тэнд очиж 7 дахь оргилдоо хөл тавьж уулын спортын түүхэнд алтан үсгээр бичигдэх амжилтаа гаргадаг ийм тив. Тэгэхээр Та бол тэр хүмүүсийн нэг болжээ. Уулын спортод 8000 метрээс дээш оргилыг “Ухлийн бүс” гэж нэрлэдэг. Та миний мэдэхээр ийм “Ухлийн бүс”-д гурван удаа орсон хүн. Энэ бүс рүү ороход Таньд юу бодогдож байв. Мэдээж айдсын тухай ярих нь ичгэвтэр байх. Та айдаг байсан бол энэ спортыг сонгохгүй байсан байх.

- Би тэр нэр томъёонд багтах 3 ууланд оролдлого хийсэн. Нэгд нь оргил дээр гарсан. Хоёрынх нь замын дундаас буцсан. Миний авиралт хийж байсан ууланд хүмүүс амь насаа алдсан учраас авиралтыг зогсоохоос өөр аргагүй болсон. Ийм үг байдаг л даа. “Та хэрвээ үхлийн бүс

рүү орох гэж байгаа бол эхлээд сайн бодоорой. Бодоод шийдвэрээ гаргаад орсон тохиолдолд ямар нэг эрсдэл тохиолдоход хаа нэгтэйгээс хэн нэгнээс таньд тусламж ирнэ гэж найдсаны ч хэрэггүй. Та өөрөө өөрийгөө л авч гар. Эс тэгж чадваас тэндээ үүрд үлдэх тийм хувь тавилан хүлээж байгаа шүү” гэсэн зарчим байдаг. Тийм болохоор тэр бүсэд ямар нэгэн хүн чанарын тухай, хүний мөсний тухай ярих боломжгүй. Нэг бодлын хэт өндөрт нэлээд хатуу, зэрлэг хууль үйлчилдэг. Хуульчлагдаагүй гурван зарчим байдаг юм. “Нэгдүгээрт нь та өөрөө өөрийгөө л авар. Хоёрдугаарт та өөрөөсөө гадна тусалж чадах хэн нэгэнд тусла. Гуравдахь нь та өөрөө өөрийгөө болон хэн нэг амьд гарах найдвартайд нь тусалж аварч гар” гэсэн гурван зарчим байдаг. Хүссэн хүсээгүй үхлийн бүсэд нэгдүгээр зарчим үйлчилдэг. Тэхээс ч өөр арга байхгүй. Тийм ч учраас “үхлийн бүс” гэж нэрлэдэг.

- Таны хэлсэн гуравдахь зарчим “Хэн амьд үлдэх найдвартайд нь тусла” гэж. Хоёр хүн байгаад хоёулаа амь өрсөн нөхцөлд байхад нэгэнд нь туслаад нөгөөгийг нь шууд л орхино гэсэн үг үү?



KILIMANJARO

(Африк)

Далайн түвшинөөс дээш 5895 м

Б.Гангаамаа 2012.02.20-нд энэ оргилд гарсан.



- Нэгэнт найдваргүй болсон хүнд туслах гэж байгаад найдвар байгаа, амьдрах боломжтой хүнээ давхар алчихаж байна гэсэн үг. Тийм учраас тэр гуравдахь зарчим үйлчилдэг. Хэрэв та нэг л хүнд өөрөөсөө илүү гарч тусалж чадахаар бол хэн амьд үлдэх найдвартайд нь тусла л гэсэн үг.

- Би Таны яриаг сонсож суухад уулчин хүн өндөр уулын эгц шовхад чулуу шигээ, нүд чихгүй шуурсан тэсгим хүйтэн салхи шигээ тийм л хатуу чанга, хүйтэн цэвдэг болчихдог, тийм л байхыг тэр орчин хүссэн ч эс хүссэн ч шаарддаг юм байна гэсэн бодол төрж байна л даа.

- Хэдийгээр бид тийм орчин, тийм газар явж байгаа ч гэсэн хамгийн хүн чанар тэнд л харагддаг. Тэгэхээр уул бол хүнийг таньдаг, хүн чанарыг таньдаг, өөрөө өөрийгөө нээдэг тийм л газар.


- Тэгэхдээ хүн чанараа яг тэр өндөрт үзүүлэх нь хэцүү юм байна шүү дээ.

- Үзүүлж болно. Тийм зөндөө олон баатарлаг үйл явдал болж байсан. Хэдийгээр баримталж байгаа зарчим нь тийм боловч яг тэнд хүн чанаргүй байх нь тэрнээсээ ч долоон дор шүү дээ. Хэрвээ чадал л байдаг юм бол хүнийг аврахын төлөө л явах

ёстой, туслахын төлөө л явах ёстой. Хүн үхэл амьдралын зааг дээр явж байхад хүний хүн чанар тэнд л харагдана. Ер нь бүх л юм харагдана даа.

- Саяын Таны ярьсан “Өндрийн хууль” ч гэх юм уу, ер нь Таны ярьсныг бодохоор Та их хатуу чанга хүн юм шиг санагдлаа. Та ер нь хир хатуу хүн бэ? Мэдээж эмэгтэй хүнийхээ хувьд зөөлөн сэтгэл байдаг байх. Гэхдээ Таны уулын амьдралын 20 гаруй жил Танд хатуу чанга байдлыг суулгасан байх.

- Би хүнийхээ хувьд их зөөлөн, маш уяхан хүн. Гэхдээ яг тийм нөхцөл байдалд хүн хатуу байхаас өөр арга байдаггүй. Нас барсан зөндөө хүмүүсийн цогсны хажуугаар гарч явахдаа тэр тийм шар толгойтой юм байна, энэ ийм шар комбинзонтой юм байна, энэ хар үстэй юм, энэ ази хүн байна, энэ европ хүн байна гээд хараад л хажуугаар нь өнгөрнө. Тэнд ямар нэгэн сэтгэл хөдлөлөө үзүүлэх ямар ч боломж байхгүй. Тэр үхчихлээ гээд хашгираад зуураад байх боломжгүй.



ELBRUS

(Европ)

Далайн түвшинөөс дээш 5642 м

Б.Гангаамаа 2010.05.25-нд энэ оргилд гарсан.

- Таны хэлснээс бодогдож байна л даа. Усчин хүн усандаа өнгөрдөг гэдэг үг байдаг. Тэхээр уулчин хүн ууландаа өнгөрөхийг тавилангаараа болжээ гэж хүлээж авдаг байх нь.

- Авирч явж байгаад амь эрсдэхэд ямар нэгэн шалтгаан байна. Зарим нь цаг агаараас болоод буруу тооцоо хийснээс амиа алдана. Зарим нь хүч чадлаа буруу тооцсоноос амиа алдана, гуравдахь нь цаг хугацаагаа буруу тооцсоноос болоод амь насаа алдана. Зарим нь хүч чадалдаа эрдэж яваад унаж амь насаа алдана, зарим нь муу хамтрагчаасаа болж амь насаа алдана гэх мэтийн олон шалтгаан байна. Аль нь ч байсан уулчин хүн явах юмандаа явж байгаад жамаараа болчихлоо гэдгийг л хүлээн зөвшөөрөхөөс өөр арга байхгүй. Хэн нэгнийг буруутгаж болохгүй. Яагаад гэвэл Таныг тийшээ яв гэж хэн ч шахаж шаардаагүй. Өөрийнхөө

хүсэл зоригоор явсан. Тийм учраас тэрнээс болж энэ үхсэн гэсэн ийм юмыг би ер хүлээн зөвшөөрдөггүй. Эрсдлээ өөрөө л үүрэх ёстой.

- Тэгэхээр “K2” бол өндөр уулын авиралтын дотроос хамгийн хэцүү 10 авиралтын нэгдүгээрт бичигддэг “Хаан уул” гэж нэрлэгддэг уул. Энэ уул Пакистаны нутаг дэвсгэрт байдаг. Мэдээж цаг уур, уулын нөхцөл байдал, дээр нь улс төрийн нөхцөл байдлаа аваад үзэхэд K2 бол хамгийн хүнд нөхцөлтэй, үнэхээр л Хаан уул. Пакистаны нутагт K2-т гарахаар явж байсан уулчид болон жуулчдыг Талибанчууд барьцаалах, буудан хороох явдал гарсан гэж хэвлэл мэдээлэлээр яригддаг шүү дээ. Ийм нөхцөл байдалтай газар руу явж байхад Танд юу бодогдож байв?

- Би 2013 онд явсан. Тэгэхэд яг наадах чинь болсон шүү дээ.

2013 онд Broad Peak (8051 метр) уулын бааз лагерь дээр дөнгөж очоод хоёр хонож байхад манай кемп менежерт мессеж ирсэн. Nanga Parbat (8125 метр) ууланд авирч байсан 12 уулчныг Талибанчууд буудчихлаа гэсэн мэдээ ирсэн. Тэр жил бол хар жил байсан. Nanga Parbat ууланд 12 уулчин Талибанчуудад алагдсан. K2-т бидэнтэй хамт явж байсан аав хүү хоёр амь насаа алдчихсан. За тэгээд Broad Peak ууланд дөрвөн уулчин нас барчихсан. G1, G2 (Gasherbrum, 8034 метр)-д бас дөрвөн уулчин нас барчихсан гэх мэт, нийтдээ 20 гаруй хүн нас барчихсан ийм хар жил байсан. Яг тэр жил би явсан. Анх би Монголоос Пакистанд очихдоо тэндэхийн зохион байгуулагч талд хандаж асууж байсан. Танайд очиход танай улс төрийн байдал чинь хир вэ гэдгийг мэдмээр байна гэсэн. Тэгээд над хэлж байсан:





ч холдохгүй” гэсэн. Тэгээд намайг очиход үнэхээр надаас огт холдоогүй. Биднийг уул хүртэл буутай цагдаа хамгаалж уулын бааз дээр авч очиж байсан. Тэгээд буцаад уулнаас бугаад ирэхэд хамгаалалт бүр их нэмэгдсэн байлаа. Би чинь нэг улсын ерөнхийлөгч шиг л явж байлаа шүү дээ. Буцаж явахдаа уулчдыг Талибанчууд алсан яг тэр газраар дайрч өнгөрдөг. Тэр нь Чилас гэдэг газар. Тэнд Талибанчууд ч юм уу, нутгийн иргэд нь ч юм уу ер нь аль нь ч танигдахгүй баахан урт сахалтай, буутай хүмүүс замаар сууж байдаг гэж манай хөтөч ярьж байсан. Тиймээс тэр нутаг аюултай бүсэд тооцогддог. Бид онгоцоор буцах байсан ч цаг агаар муудсанаас болоод машинаар явсан. Би нэг Австралийн уулчинтэй хамт буцсан. Бид хоёрын урд хойд талд хоёр машин буутай цагдаа

хамгаалж явсан. Яг Чиласын бүс рүү ороход дахиад хоёр машин буутай цэргээр нэмэлт хамгаалалт гаргасан. Тэд тал тал тийшээ буу шагайчихсан биднийг хамгаалж явсан. Надад аймшигтай гэхээсээ илүү сонин санагдаж байсан (инээв).

- Зөвхөн Та хоёрыг л хамгаалж явсан уу?

- Тийм, бид хоёрыг л хамгаалж байсан. Тэр аюултай бүсээс тэгж гаргаж өгсөн. Тэгээд би “Та нар бүх хүмүүсийг ингэж хамгаалдаг уу” гэж асуусан л даа. Тэгэхэд тэд “Ерөнхийдөө ийм хамгаалалттай байгаа. Гэхдээ Таныг арай л илүү хамгаалаад байна” гэсэн. Яагаад тэгсэн гэхээр миний аялалыг зохион байгуулсан компаний эзэн буюу үүсгэн байгуулагч нь Ашраф Аман гэдэг хүн өөрөө надад “Би монгол хүн” гэж хэлсэн. Намайг Пакистанд очоод

буудалдаа орчихоод байж байтал манай хөтөч гүйж орж ирээд манай дарга Таныг дор хүлээж байна гэсэн. Би тэр хүнтэй долоон жил И-мэйлээр харилцаж байж очсон. Би төсөөлөхдөө урт сахалтай, толгойгоо алчуураар ороосон мусульман хүн зогсож байх юм байх гэж бодоод бугаад ирсэн чинь зүгээр европ хувцастай намхан хамартай “өвгөн” зогсож байсан. Тэгээд нэг зог тусаад яваад очсон чинь Ашраф Аман гэж өөрийгөө танилцуулсанаа “Би монгол” гэж хэлэхээр нь би буруу сонсчих уу гээд “Монгол оо?” гэсэн чинь, тийм, адилхан байгаа биз дээ? “Миний өвөг дээдэс их хааны үед Монголоос нүүж ирсэн, би монгол хүн” гэсэн. Тэгээд би “Өө, К2 ууланд чинь ‘Монгол цус’ гарчихсан юм байна шүү дээ” гээд зурвасхан бодоод л өнгөрч байсан.

Тэр хүн бол К2 ууланд анх хөл тавьсан Пакистан хүн. Тэр улсдаа домог болчихсон маш алдартай хүн. Бас тэр том компанийг үүсгэн байгуулагч эзэн нь байсан. Надаас Монголын талаар их асууж, хүүхэд нь ирчихсэн юм шиг л маш сайхан хандаж байсан. Намайг ууланд очсоны дараа үргэлж утсаар асууж лавлаж байсан гэж манай менежер надад дараа нь хэлсэн. Ер нь Пакистан улсад маш их буутай хамгаалалт байдаг. Зочид буудалд хүртэл буутай хамгаалалт байсан. Ингэж К2 ууланд оролдлого хийсэн юмаа. Тэгээд Broad Peak-д би олон улсын багтай явсан. Тэнд манай багийн Ираны сайхан гурван залуу нас бараад, тэгээд би авиралтаа цуцлаад тийшээ тусламж илгээх гэж өөрийнхөө өндрийн хоёр ачаа үүрэгч туслагчаа эрлийн ажиллагаанд явуулаад өөрөө авиралтаа зогсоож байлаа. Тэр бүр цаг агаар сайхан, бүх юм бэлтгэгдчихсэн байхад тэр их цаг хугацаа, тэр их хөдөлмөр, тэр их мөнгөө золиослоод шууд авиралтаа зогсоогоод хүний төлөө явна гэдэг бол бас тэр болгон хүнд байдаггүй. Ер



нь бол үгүй гэх тийм л ажил байдаг юм. “Үгүй ээ, би цаашаа авиралтаа үргэлжлүүлнэ” гэж хэлж болох л байсан. Гэхдээ эцсийн эцэст тэнд тийм нөхцөл байдал үүсчихсэн байхад тэгж хэлбэл юу гэхэв гэхээр “Монгол” л гэнэ. Түүнээс Гангаамаа тэгсэн гэж ярихгүй шүү дээ. Эх орны минь нэр гарах, бас хүн ёсны асуудал байсан учраас би авиралтаа зогсоогоод “Монгол” гэдэг нэрийг сайнаар гаргасан.

Тэд бүгд л “Чи маш сайн юм хийлээ. Монгол хүн гэж ийм хүн байдаг юм байна” гэж ярьж байсан. Тэгэхээр хаана ч явсан ер нь эх орныхоо нэрийг бодож явах ёстой гэдгийг хэлэх гээд байгаа нь энэ л дээ.

- Хоёулаа Таны авч явдаг багаж хэрэгсэлийн тухай бас ярья. Та яаж энэ их хүнд ачааг энэ жижигхэн биендээ үүрээд дэлхийн зулай дээр гарч чадав аа? Үнэхээр төсөөлөхийн аргагүй юм. Ихэнх нь төмөр... гадас, алх, хүрз, дэгээ тэгээд бас энэ их олс. Хүнд байдаг байхаа.

- Энэ олон юмнууд чинь ихэнх нь биенд шингэчихдэг. Энэ төмрүүдийг чинь ихэнхийг нь биенээсээ зүүгээд шингээчихдэг. Үүргэвчиндээ үүрдэг зүйлс нь хоёр янз байдаг. Яг үндсэн бааз лагериасаа өндрийн хамгийн дээд кемп хүртлээ үүрч явдаг зүйлс тусдаа. Үүргэвч гэхэд





л хоёр өөр тусдаа үүргэвч байна. Хамгийн эхний кемп байгуулахдаа үүрч явдаг үүргэвч гэхэд 80-100 литрийн үүргэвч байдаг. Үүнд бүх юмаа багтааж хийгээд бааз лагериас эхлээд дундын кемп гээд кемпүүдээ байгуулаад явна шүү дээ. Шерпа (ачаа үүрэгч) болон хөтөчгүй өөрөө бүх юмаа хийж байгаа тохиолдолд ингэнэ. Хамгийн дээд талын кемпээс оргил хүртэл том үүргэвч үүрч явах шаардлага байхгүй. Дайралтын жижиг үүргэвч гэж байдаг. 5-15 литр орчмын үүргэвч. Энэ дотор 1-2 литр ус, ойр зуур идэх юм байж болно. Ялангуяа 8000 метртэй ууланд 15 литрийн үүргэвч үүрч явдаг. Жишээлбэл Эверестэд гарахад дотор нь хоёр баллон хүчилтөрөгч,

зургийн аппарат тэгээд төрийн далбаагаа хийнэ. Харин завсрын кемпүүд байгуулж байхад үндсэндээ бүхэл бүтэн гэр орноо л хийчихсэн явна шүү дээ. Майханаа үүрнэ, хөнжил гудсаа үүрнэ, биендээ өмсөөд илүү гарсан хувцсаа үүрнэ. Мөн хоол хүнс, гал тогоо, газын зуух, майхнаа барихад хэрэглэдэг цасны хүрз, олс гэх мэт. Ер нь тэгээд аль болох биендээ шингээнэ. Гартаа барихыг нь бариад, хөлдөө бэхлэхийг нь бэхлээд л явна. 100 литрийн үүргэвчинд бүгдийг нь багтаагаад л үүрнэ.

- Таны энэ гутал аварга том гутал юмаа. Бараг таниас том гутал байна (инээв). Дааж явахад хэцүү байдаг байх даа?

- Гутлыг ууланд өндөр өндрөөр нь өөр өөр байхаар зааж өгсөн байдаг. 4 мянгад өмсдөг гутал, 4-6 мянгад өмсдөг гутал, 6-8 мянгад өмсдөг гутал гэж байдаг. 8000 метрийн гутлыг 8000 метрт хоёрхон л удаа өмсөх ёстой. Гуравдахь удаа гэж байж болохгүй. Хоёроос дээш өмсөхөд дулаан хадгалах чадвар нь буурсан байдаг учраас аюулгүй байдлаа хангах үүднээс хоёр удаа л өмсөх ёстой. Гэхдээ 8 мянгад хоёр өмссөн гутлыг дараа нь 6, 7 мянгад өмсөж болно. Түүнээс зургаа юмуу долоон мянгын гутлыг найман мянгад өмсөж болохгүй, хөлгүй болно гэсэн үг.

- Нэг ийм гутал ямар үнэтэй байх вэ?

- 800-1000 ам. доллар л байгаа. Ер нь 1000 орчим ам. доллар л байдаг. Уулын багаж хэрэгсэл үнэтэй шүү.

- Уулын спорт багаж хэрэгсэл нь ч, за мөн хүний амь насаар хэмжигддэг гэдэг утгаараа ч асар үнэтэй юм. Тэгэхээр уулын спорт баян хүний спорт юм байна гэж бодогдоод байх юм.

- Уулын спорт их үнэтэй шүү. Багаж хэрэгсэлүүд өндрөөсөө хамаараад өөр өөр байдаг. Өндөрт нь тохирсон багаж, хувцас хэрэгсэлүүдийг авч хэрэглэх хэрэгтэй. Ингэж байж аюулгүй байдал хангагдаж, амжилт гаргах нөхцөл бүрдэнэ. Зориулалтын гутал, бээлийг зохих өндөрт нь өмсөхгүй бол хөл, гаргүй л болно. Тийм учраас тухайн өндөрт нь тохирсон хувцас хэрэглэлээ л хэрэглэх хэрэгтэй. Алх гэхэд л цасных, мөснийх, техникийн авиралтын гээд өөр өөр байдаг. Энэ бүх багаж хэрэгсэлийг бүгдийг нь авч явах ёстой. Яагаад гэвэл тэнд танд юу ч тохиолдож магадгүй. Цас тохиолдоход цасны алхтай байх ёстой, мөс тааралдахад мөсний шрубтэй байх ёстой гэх мэт. Зориулалтын багаж хэрэгсэлээ авч явж байж л амжилт гаргах нөхцөл чинь бүрдэж бас амь насаа хамгаалах боломж чинь нэмэгдэнэ.

- Мэдээж ууланд дээшлэх тусмаа хүйтэн, дээр нь хүчилтөрөгч багатай орчинд очдог. Тэнд ер нь ямар хоол унд иддэг вэ?

- Ер нь бол ууланд нэгдүгээрт авч явахад хөнгөн, хоёрдугаарт хурдан боловсордог, гуравдугаарт өөрт хурдан шингэдэг, дөрөвдүгээрт маш



сайн хүч чадал өгч чадах тийм л хүнс авч явах хэрэгтэй. Түүнээс биш тийм юм идэх ёстой, ийм юм идэх ёстой гэсэн юм бол байхгүй. Та юу идвэл таны биед хүч ормоор байна түүнийгээ л идэх хэрэгтэй.

- Уулын зориулалтын тусгай хоол гэж байдаг уу?

- Тийм тусгай хоол байхгүй. Аль болох савласан боосон, нунтаг зутан шөлнүүд шууд усанд хутгаад нэг минутын дотор болгоод идчихдэг тийм хоол байх хэрэгтэй. Бид ууланд ихэнхдээ борц авч явдаг. Доор байхдаа сайн идэж хүчээ сайн сэлбэж авах хэрэгтэй. Дээр бол хүн нэг их идээд байдаггүй. Доор олж авсан тэр нөөцөөрөө л оргилд гарч бууж ирэх ёстой. Мэдээж 8848 метрт гарчихаад хоол хийж идээд суугаад байна гэж байхгүй. Шингэн юм аль болох их уух хэрэгтэй. Зутан шөл их хэрэглэнэ. Зажлаад суугаад байх тийм чадал ч байхгүй. Дээр нь ходоодны хоол боловсруулах чадвар

муудчихдаг. Хүний хөдөлгөөн тэнд маш удаан болчихдог. Тэр хэмжээгээрээ хоол боловсруулах боломж их муу болдог. Түүнээс гадна бие засах асуудал байна. Битүү хувцас өмсөж өөрийгөө олс, төмрөөр багалчихаад бие засах гээд тэр бүхнийгээ тайлаад байх боломж байхгүй. Илүү хөдөлгөөн, илүү юм хийх хүч чадалгүй болчихдог.

- Яг ууланд гарахад ер нь хэдий хэр хугацаа зарцуулдаг вэ? Жишээлбэл долоогоос найман мянган метрийн өндөрт гарлаа гэхэд ямар хугацаа зарцуулдаг юм бэ?

- Уулынхаа нөхцөл байдлаас шалтгаалаад 7 мянган метртэй ууланд 25 орчим хоног, 8 мянгатай ууланд 40-50 хоног зарцуулна. Өндөртөө дасаж өндрийн бэлтгэлээ хийнэ, кемпүүдээ байгуулна, баазууд байгуулагдана, хамгаалалтын олс тавигдана, цаг агаар харна. Ингээд тухайн хүний өндрийн бэлтгэл хангагдлаа гэж үзвэл дайралт хийдэг. Авиралтаа



MOUNT VINSON

(Антарктид)

Далайн түвшинөөс дээш 4892 м

Б.Гангаамаа 2016.12.25–нд энэ оргилд гарсан.

хийхэд 5 хоног зарцуулдаг. 50-иад хоногт бэлтгэл ажлууд хийгддэг.

- Бэлтгэл ажлыг тамирчид өөрсдөө хийх үү? Тусгай хүмүүс хийх үү? Жишээлбэл олс тавилтыг хэн хийх вэ?

- Олс тавилтын баг гэж байдаг. Тэднийг томилж гаргадаг. Хоёр төрөл байна. Эхнийх нь Шерпа нар, мөн Түвдийн уулын суруулийнхан олсны баг гаргана. Тухайн жил тэчнээн хүний бүрэлдэхүүнтэй тэр тэр орно гээд тэдэнд цалин өгөөд гаргадаг. Нөгөө нэг хэлбэр нь уулчид дотроосоо олсны баг гаргаж тэд хамгаалалтын олс тавьдаг.

- Хамгаалалтын олс тавьж байгаа хүмүүсийг оргилд гараад буугаад ирж байгаа гэж ойлгож болох уу?

- Оргил хүртэл тавина. Оргилд гарна гэсэн үг. Хамгийн мундагууд, хамгийн шилдэгүүдээрээ олсыг тавиулдаг.

- Олсоо хаданд яаж бэхэлдэг вэ? Хир урт олс тавигддаг юм бол?

- Хэдэн зуун метр олсыг 6500-гаас 8848 метр хүртэл тавина. Маш их олс орно. Олсыг дагалдах хэрэгсэлүүд нь гэхээр цасны гадас, хадны гадас гээд олон багажууд байгаа. Тэдгээрийг хад руу зоохыг нь зоож, гацаахыг нь гацааж цас, мөс рүү шрубдэхийг нь шрубдэж бэхлэнэ. Ингэж тавьсан олс маань бүтэн сарын турш тэнд авирч байгаа бүх уулчдын бэхэлгээ болно. Хоёр гурван зуун уулчин тэндээс барьж татах үедээ татаж, чангаах үедээ чангааж явах учраас маш сайн стандартын байх ёстой.

- Төсөөлөхөд бэрх юм. Миний бодоход цахилгаан дриллээр тогтоох болов уу гэж бодох юм.

- Үгүй. Тэнд ямар ч цахилгаан дрилл байхгүй. Ууланд юм бэхэлж болох янз бүрийн хувилбарууд байдаг, тэр болгоныг ашиглана. Уулын багаж хэрэгсэл яагаад тийм үнэтэй байдаг юм бэ гэхээр тийм их ачааллыг дааж чадах тийм тестээр орсон, мундаг хэрэгсэлүүд байдаг учраас үнэтэй байдаг.

- Хүнд байдаг уу?

- Гадаснууд нь дандаа титанан байна. Тийм учраас хөнгөн, тэгэхдээ маш олон багаж, олон зуун метр олс нийлэхээрээ хүнд л байна шүү дээ.

- Уулчдад өндрийн өвчин тусдаг гэсэн. Энэ яг ямар өвчин байдаг вэ? Хэрвээ өндрийн өвчин туссан тохиолдолд яаж давж гарах вэ?

- Өндрийн өвчин бол өндөр авалттай холбоотой өвчин. Өндөр авалт муу хийгдэх, өндөртөө сайн дасаж чадахгүй тохиолдолд өндрийн өвчин тусгах магадлал маш өндөр байдаг. Хүний уураг тархи, цусанд хүрч очих хэрэгцээт хүчилтөрөгчийн хангамж бүрэн авч чадахгүй тохиолдолд бие организм хямардаг. Үүнийг өндрийн өвчин гэдэг. Тэр хямралын эхнийх нь ханиалгах, амьсгаадах, толгой өвдөхөөр илэрнэ. Хүндэрсэн хамгийн дээд үхэлд хүргэх хэлбэр нь оюун ухаан самуурч, өөрөө өөрийгөө удирдах чадваргүй болж төгс төгөлдөр шийдвэр гаргах боломжгүй болдог. Яаралтай арга хэмжээ авах хоёр арга байна. Нэгдүгээрт маш яаралтай нэмэгдэл хүчилтөрөгч хэрэглэх, хоёрдахь нь маш хурдан доошоогоо буух.

Түүнээс эм уугаад сайжирна гэсэн ойлголт байхгүй.

- Та ийм тохиолдолтой таарч байв уу?

- Өндөрт ихэнх уулчин бараг бүгдээрээ ханиалгадаг. Ийм ханиалгах хэлбэр надад байнга тохиолддог. Эверест ч, Деналид ч байсан. Тэр чинь бас л ялгаа байхгүй өндөрт илэрч байгаа нэг өвчин. Толгой өвдөлт бол бүх л уулчинд байдаг, зохих хэмжээний өндөр сайн аваад байх юм бол өвдөх нь багасна. Өндөртөө сайн дасаад, маш сайн идэж, хөдөлгөөнтэй байгаад шингэн юм сайн ууж цусаа шингэлээд байх юм бол толгой өвдөлт намдчихна. Ханиалгалт бол маш хэцүү, нэг л ханиалгаад эхэлсэн бол буухаас нааш намддаггүй. Иймэрхүү хүндрэлүүд надад ч гэсэн тохиолддог. Хамгийн дээд хэлбэр болох үхэлд хүргэх хэлбэр тохиолдож байгаагүй.

- Уулчид оргилд ихэвчлэн шөнө гардаг гэдэг. Түнэр харанхуйд баримжаагаа алдах, хальтираад ангал руу унах ч юмуу ер нь аймаар биш үү? Яагаад шөнө гардаг юм бол?

- Шөнө авирдаг уул, өдөр авирдаг уул гэж бий. Уулын авиралтын хоёр төрлийн хэлбэр байдаг. Хималай хэлбэрийн авиралт, Альп хэлбэрийн авиралт гэж бий. Хималай хэлбэрийн авиралт хийж байгаа тохиолдолд ихэнхдээ шөнө авирдаг. Авиралтын олс тавигдсан байдаг учраас олсонд өөрийгөө хамгаалж холбоод явдаг учраас төөрөх, өөр зам руу орох, ангал руу унах явдал байдаггүй, толгойныхоо гэрэлтэй авирна. Мөн шөнийн цаг агаар

харьцангуй тогтуун байдаг. Өглөө болоод ирэнгүүт үүл гарч эхэлдэг. Ер нь ууланд эхлэх цаг, эргэх цаг гэж байна. Ихэнх өндөр уулын цаг агаар 12.00 цагаас хойш муудаж эхэлдэг. Тийм учраас 12.00 цагаас өмнө оргилд гараад буцаж аюулгүйн кемп дээрээ ирсэн байх ёстой. Тийм учраас ихэнхдээ уулчид өглөө үүрээр оргилд гарахын тулд шөнийн авиралт хийдэг. Харин мөсөн голтой Альп хэлбэрийн авиралттай тийм ууланд шөнө авирч болохгүй. Үзэгдэх орчин харагдах болсон тохиолдолд авирдаг.

- Уулын спортын нэг сонин юм нь уралдаж нэгнээсээ түрүүлж оргил дээр гарна гэж байдаггүй. Тэгээд бодохоор өрсөлдөөнгүй спорт юм шиг санагддаг.

- Хамт авирч байгаа тохиолдолд өрсөлдөөн гэж байхгүй. Бааз лагериасаа хоёулаа өрсөлдөж уралдаж авирна гэсэн юм байхгүй. Гэхдээ аль ч спортод өрсөлдөөн гэж байна. Жишээ нь Амундсен, Скотт хоёр өмнөд

туйлд анх хөл тавих гэж яаж өрсөлдөж яваад буцахдаа нэг нь амь насаа алдсан эмгэнэлт түүх бий. Өмнөд туйлын 90 градус дээр түрүүлж хөл тавих гэж нэг нь нууцаар нөгөөдөх нь илээр хөрөнгө босгох гээд олон зовлон туулж бүтэн жил яваад очиход Амундсен 10-аад хоногийн өмнө түрүүлж очоод тугаа хатгасан байсан эмгэнэлтэй бөгөөд баатарлаг түүх байдаг. Сая би тийшээ явахын өмнө энэ түүхийг уншсан. Антрактидад ч гэсэн зурагтайгаа энэ бүх түүх байдаг юм билээ. Ийм өрсөлдөөн бол хэнд ч л гэсэн байна. Хэн ч гараагүй нэг оргилд түрүүлээд гарчих юмсан, ямар нэг том амжилтыг түрүүлж хийх юмсан гэсэн өрсөлдөөн байна. Тэр бол шударга өрсөлдөөн. Ямар ч тамирчин түрүүлээд олимпын аварга болчих юмсан гэж бодно. Харин өндөр ууланд бол бэлээс нь оргил руу уралдаж гарна гэсэн ойлголт байхгүй.

- Баримтат кинон дээрээс харж байхад уулчид ихэвчлэн нүүр амаа хайруулчихсан, гар хуруу,





чихээ хөлдөөчихсөн, маш их хүнд хэцүү нөхцөлд явж байгаа харагддаг. Таныг харахад нүүрэндээ хүйтнээс шалтгаалсан хөлдөлт түлэгдэлт аваагүй, арьс чинь их сайхан байх юм. Энэ нь хувцас хунараа тохируулж өмсөхөөс шалтгаалдаг байх даа?

- Миний арьс чинь маш олон удаа түлж, хуурч гуужиж байсан арьс шүү дээ. Энэ дайтай байгаа нь их юм. Гэхдээ бид мэдээж хамгаалалтын тос түрхдэг. SP өндөртэй тос түрхдэг. Бараг 70, 80-аас дээш 100 гаруй өндөртэй тос түрхдэг. Тэр тосыг түрхсэнээр харлахгүй байна гэвэл худлаа. Харладагаараа харлана. Харин цасны туяанаас болдог аймшгийн түлэгдэлт болох нь гайгүй. Өндөрт агаар сийрэгжсэнээс нарны туяа ямар ч хугаралгүй, сарнихгүйгээр шууд цасан дээр буугаад эргэж ойгоод нүүрэн дээр тусахаараа

түлдэг. Тэр түлэгдэлт халуун юмаар түлчихсэн юм шиг аймшгийн түлэгдэлт болдог учраас бид SP өндөртэй 100-тай 110-тай тос түрхдэг. Тэгээд давхар хамгаалалт өмсдөг.

- Мөнх цаст ууланд гарахад нүдний шилээ авч болдоггүй гэж ярьдаг, энэ талаар...

- Тийм. Нарны хэт ягаан туяа цасан дээр буугаад эргэж ойход хүний нүд сохрох магадлал өндөр байдаг. Сохорч байсан хүмүүсийг ч би харж байсан. Тийм учраас хамгийн гол нь шүүлт сайтай том битүү шил зүүж явах ёстой. Над одоо энд хоёр төрлийн шил байна. Жижгийг нь доор кемпүүд дээр зүүж болно. Томыг нь оргил руу гарахдаа зүүдэг шил.

- Ямар фирмийн шилүүд вэ?

- Шилийг үйлдвэрлэдэг олон газар бий. Харин багаж бол цөөн компани үйлдвэрлэдэг.

- Онгоцны буудал дээр харж байхад уулчид андашгүй байдаг л даа. Нүүр нь хөлдчихсэн юмуу түлэгдчихсэн, үс зүс нь ч тэр ер нь л уулчин хүн гэдэг нь танигддаг.

- Тэр чинь уулчдын имиж байхгүй юу (инээв).

- Тэхдээ л тэднээс нэг тийм эр зориг үнэртээд байдаг юм.

- Уулчдын зөвхөн нүдний эргэн тойрон нь цагаан бусад нь тэр чигээрээ тас хар болчихсон байгаа биз дээ (инээв).

- Италийн домогт уулчин Райнхолд Месснерийн тухай баримтат кино үзэж байсан. Мөн интернетээс ч гэсэн тэр хүний тухай уншиж байлаа. Райнхолд

Месснер бол Антрактид тивийг, Грийнландыг, мөн Монголын говийг явганаар туулсан хүн. Тэр бол 8000 метраас дээш 14 оргилд гарсан домогт уулчин. Энэ хүний тухай уншиж байхад Месснерийн уулын музей, Месснерийн уулын сан гэж байдаг юм байна. Мөн 80 гаруй номын зохиогч. Тэр хүн ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэгдсэн Альфийн нуруунд байдаг шилтгээнд амьдарч байх жишээтэй. Мэдээж том зах зээлтэй Европын уулчин гэдгээрээ элбэг хангалуун, харшид хаан мэт амьдарч байгаа байх. Тэгэхээр Монголын домог болсон Гангаамаа яаж амьдарч байна вэ?

- Би цалингаараа л амьдарч байна. Уулын хөтөч хийдэг. Гадныханд монголдоо, монголчууддаа гадагшаа ууланд авирахад нь хөтөч хийдэг. Энэ ажил маань улирлын чанартай л даа. 5 дугаар сараас 10 дугаар сар хүртэл дөрвөн сарын хугацаанд л хийдэг. Тэр цалингаараа л амьдралаа авч явдаг. Илүү гарсныг нь уул руугаа амжилтынхаа төлөө зарцуулна. Өвөлд нь олон нийтийн буюу нийгмийн тустай ажил хийнэ. Энэ тэнд хүмүүст лекц, сургалт хийнэ. Яг үнэндээ

нэг их орлогогүй мөртлөө завгүй л явах юм байна шүү дээ.


- Лекц гэснээс гадаадын том уулчдын намтар түүхийг уншиж байхад тэд том том компаниудын Гүйцэтгэх захирлууд (СЕО)-д эрсдэлийн удирдлагын хичээл заадаг, тэдэнтэй хамтарч ажилладаг, түүгээрээ цалинждаг юм байна. Мэдээж өндөр ууланд авирна, экстрем спортоор хичээллэнэ гэдэг бол Таны амьдралын ихэнх хугацаа үүнд зориулагддаг учраас эрсдэлийг даван туулах өөрийн гэсэн арга техниктэй болсон байдаг байх. Энэ талаараа монголынхоо том компаниудын захирлууд, байгууллагуудад лекц унших, хичээл заах төлөвлөгөө бий юу?

- Миний лекц ихэнхдээ уулын спортынхоо сэдэвтэй, танин мэдэхүйн чиглэлийн, мөн яаж амжилтанд хүрэх вэ, яаж өөрийгөө ялж дийлэх вэ, яаж хөдөлмөрлөх вэ гэдэг уулынхаа спортыг түшиглэсэн лекцүүд байдаг. Энэ чиглэлийн юм сонирхдог хүмүүс урьж лекц уншуулдаг л даа. Бас цэргийн ангиудад яаж тэвчээртэй эх оронч байх вэ зэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр сүүлийн хоёр, гурван жил лекц

уншиж хамтарч ажиллаж байна. Мөн Төмөр зам зэрэг олон байгууллагад лекц уншсан. Ер нь лекц уншуулья гэсэн захиалга их ирдэг. Харамсалтай нь миний зав болохгүй хойшлуулаад байх тал бий.

- Түрүүн Та бид хоёр Райнхолд Месснерийн тухай ярьсан. Райнхолд Месснер 2009-2014 онд Италийн Ногоон намаас Европын парламентад гишүүнээр сонгогдож байсан юм билээ. Парламентын гишүүн байхдаа байгаль орчин, хүний эрхийн асуудал хариуцаж ажиллаж байсан. Танд хэзээ нэгэн цагт улс төрд орж парламентын гишүүн болоод уулын спортыг Монголд хөгжүүлэх, за тэгээд ганц уулын спорт гэлтгүйгээр бусад спортын төрлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах юмсан гэсэн холын бодол бий юу?

- Яг үнэндээ надад спортоос гадна байгаль орчны асуудал миний сэтгэлд байнга байдаг. Гэхдээ би сайн мэдэхгүй байна. Заавал улс төрд орж байж үүний төлөө явах юм болов уу эсвэл өөр арга байна уу. Ер нь улс төр чинь жаахан түвэгтэй юм биш үү. Би улс төрөөс их хол шүү дээ. Спортынхон угаасаа улс



CARSTENSZ PYRAMID

(Далайн ноён оргил)

Далайн түвшинөөс дээш 4884 м

Б.Гангаамаа 2016.07.08–нд энэ оргилд гарсан.



төрөөс хол байдаг. Одоогоор бол тийм төлөвлөгөө байхгүй байна. Харин улс төрд орж байж л байгаль орчны, уулын спорт, аялал жуулчлалын талаар миний бодож санаж явдаг зүйл хэрэгжих хэрэгтэй гэвэл би ороход бэлэн. Гэхдээ өнөөдөр биш, маргааш биш. Ер нь олон асуудал нүдэн дээр харагдаад байдаг л даа. Яагаад гэвэл би дэлхийн долоон тивийн ноён оргилд авирахад олон улс орны байгалийг харж явлаа шүү дээ. Тэдгээр орны үндэсний парк нь ямар байдаг гэдэг ч юм уу, манайх нэг тэгчихмээр л байх юм даа гээд боддог. Тэгэхээр энэ бүхнийг заавал улс төрд орж байж хэрэгжүүлэх ёстой юм уу эсвэл хэлж яриад хэрэгжүүлж болдог юм уу би сайн хэлж мэдэхгүй байна. Энэ талаар би хэзээд дуугарах болно, ярих болно. Хэрвээ миний дуу хоолой заавал улс төрд орж байж л хүнд хүрч байгаа бол би улс төрд ороход бэлэн л гэж бодож байна. Гэхдээ улс төр бол хэцүү. Яг үнэндээ бол түүнийг болж өгвөл хүсмээргүй байна.

- Миний нэг найз уулчин байдаг л даа. Сутай хайрханы

оргилд гараад ирсэнийх нь дараа тааралдаад орой дээр нь гарчихаад яг ямар бодол төрөв гэж асуухад “Яаж энийг хамгаалах вэ л гэсэн бодол төрсөн. Өөр ямар ч бодол төрөөгүй” гэж байсан. Танд эх орныхоо оргилууд дээр гарахад яг ямар бодол төрж байв?

- Бид одооноос эхлэн хүүхдүүдийн толгойд байгаль орчноо яаж хамгаалах вэ, яаж цэвэр, онгон тагшнаар нь авч үлдэх вэ гэдэг талаар л сайн суулгаж өгөх хэрэгтэй юм шиг санагддаг. Би ууланд авирч явахдаа үүнийг л их бодож явдаг.

- Та бол монголдоо төдийгүй дэлхий нийтэд өөрийн гэсэн шүтэн бишрэгчидтэй. Таны энэ хийсэн амжилтыг үнэлдэг олон хүмүүс, пүүс компаниуд байдаг юм байна. Та надад энэ хутгыг бэлэглэсэн байгаа. Энэ хутгыг Францын Опинел гэдэг компани Таныг сая Дэлхийн долоон тивийн ноён оргилд гараад ирэхэд “Дэлхийн долоон тивийн ноён оргилд хөл тавьсан анхны монгол хүн Бадамгаравын Гангаамаа” гэж Таны нэрийг

сийлээд найз нөхөд, уулзаж учирсан дотны хүмүүстээ өгөөрэй гэж энэ бэлгийг явуулсан байна. Монголд Таны энэ амжилтыг хүмүүс хир ойлгож, хир үнэлэж цэгнэж байгаа нь Танд анзаарагдаж байна вэ?

- Дэлхийд хамт авирснаа бодох юм бол би дэлхийгээр дүүрэн найзуудтай. Дэлхийн олон улс орнуудад байдаг компаниуд бас намайг дэмждэг. Тэдний нэг нь энэ хутгыг 1890 оноос хойш үйлдвэрлэж ирсэн Францын “OPINEL” компани. Энэ бол маш алдартай хутга юм билээ. Мөн “The Seven Summits” гэдэг уулын аялалын дэлгүүртэй Монголд салбар нь байдаг “Blue Wandana” гэж герман эзэнтэй германы компани байгаа. Энэ хоёр хамтарч энэ хутгыг надад бэлэглэсэн (олныг хийж ирүүлсэн). Ийм амжилтанд хүрсэн юм чинь маш их бэлэг хэрэгтэй гэж. Дэмжлэг гэдэг чинь янз бүрийн хэлбэртэй шүү дээ. Мөнгөн хэлбэрээр байж болно, эд материалын хэлбэрээр, оюуны хэлбэрээр эсвэл сэтгэл санаагаара дэмжиж болно. Зүрх сэтгэлээрээ хамт байж болно. Энэ бүхэн чинь бүгдээрээ л дэмжлэг. Тэгэхээр монголчууд маань бүгдээрээ л миний амжилтыг ойлгож дэмжиж байгаа.

- Би Таны энэ бэлгийг аваад их баярласан л даа. Хэзээ нэгэн цагт Таны нэртэй Монгол бренд бий болох байхаа гэж найдаж байна.

- Баярлалаа. Манай үндэсний компаниуд Та бид хоёрын яриг сонсож байгаа бол хийж болох л юм байна шүү дээ (инээв). Гэхдээ брендийнхээ нэрийг заавал Гангаамаа гэх албагүй шүү дээ. Брендийн нэрний хамгийн гол



MOUNT KOSCIUSZKO

(Австрали)

Далайн түвшинөөс дээш 2228 м

Б.Гангаамаа 2016.07.17-нд энэ оргилд гарсан.

утга нь юу вэ гэхээр “Долоон тивийн ноён оргилд гарсан анхны Монгол хүн” гэдэг чинь л хамгийн том нэр. Үүний ард Гангаамааг залгах шаардлагагүй, зүгээр л монголын анхны Seven Summitter гээд бичихэд л болчихно.

- Та Seven Summits-ийг хийж ирээд Facebook хуудсандаа “Үүнээс цааш газар үгүй” гэж бичсэн. Энэ чинь зодог тайлана гэсэн үг биш биз дээ?

- Биш биш. Би хоёр үг хэлсэн шүү дээ. Нэг нь “Бид дэлхийг хураалаа”, нөгөөх нь “Үүнээс цааш газар үгүй” гэж хэлсэн. Энэ хоёр үг бол хоорондоо

холбоотой үг. Маш омогшиж хэлсэн үг л дээ. Яагаад гэвэл дэлхий долоон том эх газар болон арлуудаас бүрдэж байна. Тэр долоон эх газрын хамгийн хамгийн өндөр цэг дээр төрийнхөө далбааг мандуулчихлаа. Тэгэхээр тэр долоон тивээ хураачихлаа гэсэн үг. Наймдахь эх газар гэж байхгүй шүү дээ. Тийм болохоор “Үүнээс цааш газар үгүй” гэж хэлсэн юм. Зодог тайлах бол мэдээж болоогүй. Цаана нь надад гарах оргил, чадвал хийчих юмсан гэсэн мөрөөдөл байгаа.

- Таны тэр мөрөөдлийн оргил юу вэ?

- Эхний нэг мөрөөдөл бол Seven Summits буюу Долоон тивийн ноён оргил байсан. Түүнийгээ хийчихлээ. Одоо миний мөрөөдлийн нэг оргил байгаа. Тэр бол K2.

- Таны хийсэн энэ амжилтыг дэлхийд 140 гаруйхан хүн хийсэн байдаг юм байна. Тэгэхээр бусад спорттой харьцуулаад үзвэл Та дэлхийн аварга болжээ. Таныг дэлхийн аваргатай дүйцэхүйц энэ том гавьяаг байгуулаад ирэхэд танай нутгийн зөвлөл юу өгсөн бэ? Яагаад би нутгийн зөвлөл юу өгөв гэж асууж байна вэ гэхээр тухайлбал, манай үндэсний бөхийн начин төрлөө гэхэд нутгийн зөвлөл нь суурь хонь, азрага адуу, за тэгээд Land 200 шууд л өгдөг шүү дээ. Таныг монголын спортын түүхэнд домог болох түүхийг бичээд ирэхэд танай Завхан нутгийн зөвлөл Танд яг юу өгсөн бэ?

- Тэрийг би яг үнэндээ хэлж мэдэхгүй байна. Наадах чинь жаахан хүнд асуулт байна. Яагаад гэвэл энэ чинь надаас шалтгаалах зүйл биш шүү дээ. Ер нь юм өгөх өгөхгүй асуудал бол тухайн хүний л асуудал учраас заавал надад өгөх албагүй ч байж болно шүү дээ.



MOUNT KOSCIUSZKO



- Аварга гэдэг үг яг Таны энэ гаргасан амжилтанд тохирохгүй юм шиг надад санагддаг. Яагаад гэвэл, энэ бол “Баатарлаг үйлс” юм. Ийм бааатарлаг үйлс бүтээгээд ирэхэд манай БСШУСЯ-ын сайд, за мөн Монгол улсын Ерөнхийлөгч Таныг тусгайлан хүлээн авч уулзаж баяр хүргэсэн үү?

- За яахав миний амжилтыг Та их өргөөд байх шиг байна. Ямар ч байсан зорьсон зорилгоо биелүүлсэн. Хичээл зүтгэл, хөдөлмөр орсон уу гэвэл орсон, орох орохдоо маш олон жилийн хөдөлмөр, маш олон жилийн зүтгэл маань л өнөөдрийн энэ үр дүнд хүрч энэ амжилтыг авчирлаа. Мэдээж монголын ард түмэн маш их тусалсан. Ирсний дараа би сайдтай бол уулзсан.

- Та өөрөө хүсэлт гаргаж уулзсан уу, сайд өөрөө Таныг хүлээж авч уулзсан уу?

- За ямар ч байсан манай биеийн тамир, спортын удирдах байгууллагаас л зохицуулсан. Яг яасныг нь мэдэхгүй. Тамирчин хүний хувьд би яваад амжилт гаргаад ирлээ. Дарга нар л бусдыг нь зохицуулдаг. Одоо тийм хүнтэй уулзана, тийм хэвлэлд ярилцлага өгнө гэх мэт. Зохион байгуулсан хүмүүс нь тамирчныгаа яах вэ гэдэг нь тэдний л асуудал шүү дээ. Яваад ирлээ, тэгээд л байж байна. Ерөнхийлөгч бол хүлээж аваагүй ээ.

- Би хүүхэд байхдаа хүн төрлөхтний дотроос анх удаа Эверестийн оргилд гарсан төвдийн уулчин Дэнзэн Норгойн тухай “Цаст уулын цагаан барс” гэдэг ном уншиж байсан. Түүний тэр түүхэн амжилт бас тэр номын нэр надад их гүн сэтгэгдэл үлдээсэн л дээ. Би Таныг Seven Summits хийсэн тэр үед ч, яг одоо Тантай ингээд нүүр тулаад ярьж суухад ч Таныг “Цаст уулын цагаан ирвэс” гэж нэрлэмээр санагдаад байна л даа. Танд нэг нэр өгмөөр санагдаад,



нэг тийм гоё нэр... “Цаст уулсын цагаан ирвэс” гэж...

- Баярлалаа. Надад бараг ахдахаар их том нэр байна. Үнэхээр гоё нэр байна. Би тэр нэрийг авах хэмжээний гавьяа байгуулж чадсан ч юм уу үгүй ч юм уу түүнийг би хэлж мэдэхгүй шүү дээ. Энэ бол их том нэр, их аугаа нэр. Дэнзэн Норгой гуайн хувьд хүн төрлөхтнөөс анх удаа дэлхийн зулай дээр хөл тавьсан хүн. Миний хувьд анх удаа Монголоос энэ амжилтыг үзүүллээ. Гэхдээ би ийм амжилтанд хүрсэн, ийм шагнал авах ёстой гэж хэлмээргүй байна л даа. Яагаад гэвэл, тэртэй тэргүй хүмүүс мэдэж байгаа, үнэлж байгаа. Миний хувьд өөрийн зорьсон зорилгодоо хүрлээ, тэр зорилгын төлөө явсан. Миний хүсэл зорилго юу байсан бэ гэвэл монгол хүн долоон тивийн ноён оргилд гарах ёстой түүнийг нь би хийчих юмсан, Seven Summits-ийн жагсаалтанд Монгол гээд бичүүлчих юмсан гэсэн зорилго байсан түүндээ хүрлээ. Үүнийг яаж үнэлэх нь ард түмний л асуудал. Юу гэж нэр өгөх нь ч гэсэн, гэхдээ Таны надад өгч буй нэр үнэхээр их таалагдлаа. Миний амжилтыг ингэж их үнэлж байгаа Танд баярлалаа.

- Би Танд одон медаль, мөнгө төгрөг өгч чадахгүй учраас ийм нэр бодож олсон юм. Бодож олох ч юу байхав Дэнзэн Норгой гуайн нэр, түүний тухай тэр номын сайхан нэр миний сэтгэл зүрхэнд байнга байдаг л даа.

- Тэр үнэлгээ, хүмүүс тэгж нэр бодож олж өгч байгаа, баяр хүргэж алга ташиж байгаа, сайхан үг хэлж байгаа, тэр их хүндлэл хайр гэдэг чинь миний хувьд маш том хариуцлага юм. Түүнийг дааж, зөв авч явна гэдэг бол надад хамгийн том ачаа юм. Тэр ачааг л би дааж явах юмсан гэж л бодож байна. Өөр юм бодогдохгүй байна (нулимс гаргав), (“Цаст уулын цагаан ирвэс” ... давтан хэлэв. - Л.С.).

